

**ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

№ 20/01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нью Майнд ХХК-ийн байрны 3 давхрын хурлын өрөөнд цахимаар хуралдав.

Цахим хуралд ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга О.Болдбаатар, ТУЗ-ийн дарга Б.Дэлгэржаргал, Компанийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал, ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал, Тооллогын комиссын дарга, Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанликс ХХН-ийн партнер С.Батбуян, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг нар оролцов.

Хурлыг ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хөтлөн явууллаа.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох; Ердийн гишүүнд нэр дэвшигчигчийг сонгох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах;
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн батлах эсэх асуудал;
6. Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг дагуу тооллогын комиссын дарга, Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН-ийн партнер С.Батбуян хурлын ирцийг танилцуулав.

ЛэндМН ББСБ ХК-ийн 2020 оны 03 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид 'ХЭЭХ' гэх/-д 2020 оны 02 сарын 25-ны өдөр буюу бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 796,000,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 4,259 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 80 хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь 642,780,384 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхийн 80.75% болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69.1-т зааснаар ХЭЭХ хуралдуулах ирц бүрдсэн тул хувьцаа эзэмшигчид болон ХЭЭХ-ын даргад мэдээлж байна.

ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар нээж үг хэлэв.

Хувьцаа эзэмшигчид болон Файсбүүкээр ХЭЭХ-ыг үзэж байгаа харилцагч, хэрэглэгчид болон хөрөнгийн зах зээлийн оролцогчид нартаа энэ өдрийн мэнд хүргэе!

Тооллогын комиссын даргын мэдээлснээр хурлын ирц бүрдсэн тул хурал албан ёсоор эхэлж байна.

Дэлхийн нийтэд короно вирусийн тархалт нэмэгдэж өнөөдөр өглөөний байдлаар 597 мянган хүн халдвар авсан, 27 мянган хүн нас барсан, мөн өчигдөр орой Англи улсын Ерөнхий сайд Борис Жонсон хүртэл уг өвчний халдвар авсан гэдгээ мэдэгдсэн байгаа ийм цаг үе тохиож байгаа учир бид ХЭЭХ-аа цахимаар хийж байна.

ЛэндМН ББСБ компани энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэсэн байсан ба Засгийн газраас онцгой байдал зарласантай

холбоотой хурлаа тодорхойгүй хугацаагаар хойшлуулахаар шийдвэрлэсэн байсан. Гэвч Санхүүгийн Зохицуулах Хороо /СЗХ/-оос Компанийн тухай хуулийн дагуу ХЭЭХ-ыг цахимаар зохион байгуулж болно гэсэн мэдэгдэл, уриалга гаргасны дагуу бид хурлаа цахимаар хийж байна.

Бидний хувьд ХЭЭХ-ийн хурлаа цахимаар хийж байгаа хамгийн анхны компани болж байгаа учир алдаа, дутагдалтай зүйл гарвал ойлгож хандана уу хэмээн хүсч байна.

ХЭЭХ фэйсбүүкээр шууд явж байна. Хувьцаа эзэмшигчид маань тус хуралд зориулан хөгжүүлсэн survey.lend.mn вэб хуудсаар орж ирцээ бүртгүүлээд, хурлаар хэлэлцэж буй асуудлуудад санал өгнө. Мөн хурлын үеэр асуух зүйл байвал тухайн вэб хуудасны асуулт гэсэн хэсэгт асуултуудаа явуулж болно. Харин фэйсбүүк хуудаст ирсэн асуултаас авахгүй болохыг мэдэгдэж байна.

Та бүхэндээ хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулъя.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх нийт 6 асуудал байгаа. Эдгээр асуудлийг хэлэлцэж дууссаны дараа асуулт, хариултын хэсэг явна. Санал хураах хуудаст нэвтрэх, эсвэл санал өгөхөд ямар нэгэн хүндрэл гарсан тохиолдолд компанийн лавлах төвийн 7707-0101 дугаарт залган техникийн туслалцаа авч болно. Асуулт, хариулт хурлын дэгийн дагуу 15 минут үргэлжилнэ. Үүний дараа санал хураалтын хэсэг явж, Тооллогын комиссоос санал хураалтын дүнг танилцуулсаны дараа энэхүү хурлаар батлах тогтоол, шийдвэрүүдийг танилцуулсанаар өнөөдрийн хурал өндөрлөнө.

Хэлэлцрх асуудал 1: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах

Танилцуулсан нь: О.Болдбаатар, ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал

Миний бие ЛэндМН компанийн үүсгэн байгуулагчдын нэг. 2019 оны 8 дугаар сараас хойш ЛэндМН компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Үйл ажиллагааны тайланг танилцуулахаас өмнө 2019 оноо дүгнээд хэлбэл бидний 2016, 2017 онд эхэлж байсан старт ап компани маань 2018 онд өсөлтийн жилрүү орж байсан бол 2019 оны хувьд илүү тогтворжих шат руу орлоо. Өнөөдөр бид сардаа 150 мянган харилцагчдад үйлчлэх томоохон санхүүгийн байгууллага болж төлөвшилтийн шатандаа орж байна. 2019 онд зээлийн харилцагчид, хэрэглэгчдийн тоо тогтвортой өсч, цэвэр ашгийн хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн. Нийт хувьцаа эзэмшигчиддээ 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн. 2019 оны ерөнхий үзүүлэлтүүдийг харвал 2020 онд төлөвлөгөөний дагуу ажиллах, цааш цаашдын шинэ бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэх, компанийг хөгжүүлэх бүх суурь үзүүлэлтүүд бүрдсэн гэж үзэж байгаа.

Үйл ажиллагааны тайлан

- ✓ СЗХ-оос факторингийн болон итгэлцлийн 2 тусгай зөвшөөрөл нэмж авсан ба зөвшөөрлийн дагуу үйл ажиллагааг эхлүүлээд явж байна.
- ✓ Гадаад валют арилжааны тусгай зөвшөөрөл авсан. Энэ зөвшөөрлийн хүрээнд Tunes компанитай хамтран олон улсын мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба гадаадын нэлээд олон орноос Монгол Улс руу мөнгөн гуйвуулгыг хүлээн авч байгаа. Удахгүй гадаад улсууд руу мөнгөн гуйвуулга хийх үйлчилгээг нэвтрүүлэхээр хууль, эрхзүйн орчныг судлан ажиллаж байна.
- ✓ Өнгөрсөн ХЭЭХ-аар бид дараа дараагийн шинэ бүтээгдэхүүнийг гаргана гэж танилцуулж байсан. Үүний нэг жишээ нь татан авалтын зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлсэн ба энэ нь найман нэрийн дэлгүүрүүд өөрсдийн хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг татан авахдаа ЛэндМН-ий апп-аа ашиглан зээлээр бараагаа татан авдаг үйлчилгээ байгаа. 2019 онд 1.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон.
- ✓ 2020 онд хэрэгжүүлэх бусад бичил зээлийн бүтээгдэхүүнүүдийн хөгжүүлэлт хийгдээд явж байгаа.
- ✓ 2019 оны 7-р сард Play Time арга хэмжээнд ерөнхий спонсороор оролцсон.
- ✓ ЛэндМН апп-ийн татан авалтын тоо 1 саяд хүрч Монголын топ 3 апп-ийн нэг болж чадсан.

- ✓ ЛэндМН компани охин компани байгуулж, Монголбанкнаас цахим мөнгөний нэмэлт тусгай зөвшөөрөл авахаар ажиллаж байна.
- ✓ Asia Money олон улсын сэтгүүлээс Монголын банк, санхүүгийн салбарын шилдгүүдийг тодруулдаг ба ЛэндМН ББСБ 2019 оны Шилдэг дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар шалгарсан.
- ✓ Гаднаас эх үүсвэр татах зорилгоор Латви улсад байдаг Mintos Financial Platform дээр гарах бэлтгэл ажлуудаа хийгээд явж байна. Тус платпформд орохоос өмнө компанид хийгддэг үнэлгээгээр B+ гэсэн үнэлгээ авсан.
- ✓ 2019 онд 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 1.2 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.
- ✓ ЛэндМН апп-ийг 1 сая удаа татан авсан ба үүнээс 712,000 бүртгэлтэй харилцагч байгаа ба зээлийн гэрээ байгуулан харилцагч болсон 166,000 харилцагч байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 1.7 дахин өсөлттэй байна. Олгосон зээлийн хэмжээ өдөртөө 6,000 – 7,000 ширхэг, жилдээ 1.9 сая ширхэг зээлийг ард иргэддээ олгосон байна. Мөнгөн дүнгээр авч үзвэл 424 тэрбум төгрөгийн зээлийг гаргасан байна.

Санхүүгийн тайлан

Компанийн санхүүгийн тайлан олон улсын аудитын Эрнст энд Янг Монголиа компаниар аудитлагдан баталгаажсан. Санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийг танилцуулъя.

- ✓ 2018 онд 24 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2019 онд 58 тэрбум болж өссөн. Үүнд эздийн өмч ордог ба энэ нь хувьцаа эзэмшигч та бидний хөрөнгө 14 тэрбум төгрөгөөс 17 тэрбум төгрөгт хүрсэн.
- ✓ Цэвэр орлогын хувьд 2018 онд 6 тэрбум төгрөгийн орлоготой байсан бол 2019 онд 13 тэрбум төгрөгт хүрсэн. Цэвэр ашиг өмнөх онд 2.5 тэрбум байсан бол 2019 онд 4.9 тэрбум төгрөг болж өссөн.
- ✓ Нэгж хувьцаанд ногдох өгөөж 2017 онд 0.2 төгрөг байсан бол 2019 онд 6 төгрөг болж өссөн.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

Танилцуулсан нь: Б.Дэлгэржаргал, ТУЗ-ийн дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Анд системс ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал

- ✓ Компанийн ТУЗ улирал бүр тогтмол ээлжит хурал, шаардлагатай үед ээлжит бус хурлаа зохион байгуулж компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, бизнесийн болон стратегийн хувьд шаардлагатай зөвлөмж чиглүүлгийн өгч, тогтоол шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороод үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдэд хяналт тавьж, ТУЗ-д тайлагнаад явдаг.
- ✓ ЛэндМН-ийн бизнесийн үйл ажиллагаа өнгөрсөн 2019 онд 2 дахин өсөлттэй, маш амжилттай байсан. Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн тоо 2 дахин, зээлдэгчийн тоо 1.7 дахин, зээл олголт 2.6 дахин өссөн. Үүнээс гадна зээлийн багцын хувьд ялангуяа эрсдэлийн удирдлагын хувьд сайн байсан гэж үзэж байгаа. Банк болон банк бус санхүүгийн салбарын зээлийн багцын чанартай харьцуулахад хангалттай, сайн түвшинд байна гэж дүгнэсэн.
- ✓ Нийт активын хэмжээ өнгөрсөн 2018 онд 24 тэрбум байсан бол 2019 оны эцсээр 58 тэрбум төгрөгт хүрч 2.4 дахин өссөн. Нийт орлогын хэмжээ 2.5 дахин өссөн. Зээлийн багц 19 тэрбум байсан бол 50 тэрбум болж өслөө. Компанийн хувьд татварын өмнөх ашиг 6 тэрбум, татварын дараах ашиг 4.9 тэрбум төгрөг байна.
- ✓ Бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд олон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн, зарим бүтээгдэхүүнүүд туршигдаад явж байна.
- ✓ Цахим төлбөр тооцооны үйлчилгээ нэлээд өргөжиж, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Банк бус санхүүгийн салбарын үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн энэхүү үйл ажиллагааг цаашид охин компаниараа дамжуулан үзүүлэх шийдвэрийг гаргасан.

- ✓ Зах зээл дээр нэлээд олон зээлийн апп, цахимаар зээл олгох үйлчилгээнүүд нэвтэрч байгаа хэдий ч ЛэндМН тэргүүлэх байр сууриа хадгалсаар байгаа. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн салбарт нийт зээлдэгчийн тоо 400,000 гаруй болж өссөн ба ЛэндМН зах зээл дээр 40%-ийг эзэлсэн байр сууриа хадгалсаар байна. Зээлийн дансны тоогоор авч үзвэл банк болон банк бус санхүүгийн салбарын нийт иргэдэд олгосон зээлийн дансны 10 гаруй хувийг дангаараа эзэлж байгаа нь бид бүхэн нийт иргэдэд санхүүгийн хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилтоо биелүүлэн ажиллаж байгаа гэж үзэж болохоор байна.

2020 оны 2 сарын 03-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаар компанийн 2019 оны үйл ажиллагааг **‘хангалттай’** гэж дүгнэсэн.

Өнөөдрийн ХЭЭХ-аар Компанийн санхүүгийн аудитлагдсан тайланг батлах ёстой байгаа. Компанийн тухай хууль болон ЛэндМН-ийн дүрмийн дагуу ТУЗ-өөс 2019 оны санхүүгийн тайланг Эрнст энд Янг Монгол ХХК-аар аудитлуулахаар шийдвэрлэсэн. Тус компанийн хувьд ЛэндМН-ийн санхүүгийн тайланд 3 дахь жилдээ хөндлөнгийн аудит хийсэн. Тус аудитын компанийн зүгээс ЛэндМН-ий 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, олон улсын стандартын дагуу гаргасан жилийн аудитлагдсан тайлантай тохирч байна гэсэн дүгнэлт гаргасан. Тус тайланг 2020 оны 02 сарын 03-ны өдөр Аудитын хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцээд тайланг хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргасан.

Иймд өнөөдрийн ХЭЭХ-аар ТУЗ-өөс ЛэндМН-ий 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталж өгөхийг Та бүхнээс хүсч байна.

Хэлэлцрэх асуудал 3: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох

Танилцуулсан нь: Б.Дэлгэржаргал

ТУЗ-өөс ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох мөн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох асуудлыг ХЭЭХ-д оруулж байна.

Үүнтэй уялдан ТУЗ-ийн өнгөрсөн нэг жилийн хугацааны тайланг товч танилцуулъя.

- ✓ Өнгөрсөн жилийн ХЭЭХ-аар Компанийн тухай хууль, ЛэндМН-ийн дүрмийн дагуу ТУЗ нэг жилийн хугацаатай томилогдсон. ХЭЭХ-аас томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүн бүхий ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ердийн гишүүнээр томилогдсон байсан ноён Мэтью Вэлч өөрийн биеэр ТУЗ-өөс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөний дагуу ТУЗ тухайн гишүүний хүсэлтийг хүлээн авч, ердийн гишүүнээс 8 сард чөлөөлсөн. Иймд өнгөрсөн оны 8 сараас хойш ТУЗ нь 8 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн.
- ✓ Нэг жилийн хугацаанд ТУЗ 5 удаа ээлжит, 11 удаа ээлжит бусаар хуралдсан. 2020 он гарсанаас хойш 2 удаа ээлжит бусаар хуралдсан.
- ✓ ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 3 удаа, он гарсанаас хойш 1 удаа, Эрсдэлийн удирдлагын хороо 3 удаа, он гарсанаас хойш 1 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 4 удаа, он гарсанаас хойш 1 удаа хуралдсан. ТУЗ тогтмол хуралдаж, холбогдох чиглэлээр тайлан, дүгнэлтүүдээ өгч ажиллаж байна.
- ✓ Өнгөрсөн нэг жилийн хугацаанд ТУЗ-өөс 62 тогтоол гаргасан ба үүнээс 28 нь компанийн бизнесийн үйл ажиллагааны өсөлтийг хангахад чиглэсэн эх үүсвэртэй холбоотой тогтоол байна. Компанийн эх үүсвэр 2018 оны эцсээр 10 тэрбум төгрөг байсан бол 2019 оны эцсээр зээлийн эх үүсвэр 38 тэрбум төгрөгт хүрсэн.
- ✓ ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааг зөв зохистой удирдахад чиглэсэн бодлогын бичиг баримтуудыг батлан, тэдгээрийн дагуу улирал болгон тайланг сонсон, хяналт тавьж ажиллаж байна. Тухайлбал Эрсдэлийн удирдлагын бодлого, Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого, Эх үүсвэрийн төлөвлөгөө, Зээлийн удирдлагын сангийн ангилал, зарцуулалт, Ёс зүйн дүрэм гэх мэт чухал бичиг баримтуудыг батласан.

- ✓ Түүнчлэн компанийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой шийдвэрүүд, тухайлбал Компанийн засаглал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, компанийн бүтэц, мөн шинэ Гүйцэтгэх захирал томилох зэрэг шийдвэрүүдийг гаргасан.
- ✓ Сонирхлын зөрчилтэй хэлцэлүүдийг ТУЗ-өөр баталдаг. Хувьцаа эзэмшигчдийн хувьд ТУЗ-өөс гарсан шийдвэрүүдийг Хөрөнгийн биржийн сайтаас харах боломжтой. Ялангуяа сонирхлын зөрчилтэй шийдвэрүүдийн хувьд компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн өсөлтийг хангахад чиглэсэн эх үүсвэртэй холбоотой шийдвэрүүд гарсан. Тухайлбал, холдинг компани болох Анд системс ХХК, Анд системс тех ХХК-уудаас тодорхой хэмжээний эх үүсвэр татах, мөн Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК-ийн удирдлага Н.Цэвэгмид захирал ТУЗ-ийн бүрэлдэхүүнд багтдаг учир, тус ҮЦК-тай зөвлөх үйлчилгээний болон андеррайтерийн гэрээ байгуулах зарим шийдвэрүүд гарсан байгаа.
- ✓ ЛэндМН-ийн төлбөр тооцооны үйлчилгээ нэлээд өргөжиж байна. Үүнтэй холбоотой банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу СЗХ-оос зөвшөөрөл авсан үйл ажиллагаа явуулах ёстой гэсэн зохицуулалттай байдаг. Гэтэл Үндэсний төлбөрийн системийн хуулиар шинэ шаардлага гарч Монголбанкнаас зөвшөөрөл авах шаардлага үүссэн. Үүнтэй холбоотойгоор охин компаниар дамжуулан үйл ажиллагаа явуулах нь оновчтой юм байна гэсэн шийдвэр гаргасны үндсэн дээр өнгөрсөн оны 12 сард ЛэндМН-ий дор цахим төлбөрийн үйл ажиллагаа явуулах, компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулахаар шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн компанийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатар тус компанийг төлөөлөн холбогдох шийдвэр гаргах эрхийг олгосон шийдвэрийг гаргасан.

Компанийн дүрмийн дагуу ТУЗ нэг жилийн хугацаатайгаар томилогддог. Гүйцэтгэх удирдлагын зүгээс ТУЗ-ийн гишүүд өнгөрсөн хугацаанд компанийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тодорхой хувь нэмэр оруулсан гэсэн үндэслэлээр ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох саналыг ЗНДЦУ-ын хороонд танилцуулж, тус хорооноос холбогдох дүгнэлтийг гаргаж ТУЗ-өөр хэлэлцүүлсэн **/ЗНДЦУ-ын хорооны 2020.02.03-ны өдрийн хурлын дүгнэлтийг хавсаргав/**.

ТУЗ-ийн одоо ажиллаж байгаа ердийн 5, хараат бус 3 гишүүнийг улируулан сонгох саналыг ХЭЭХ-д танилцуулж, шийдвэрлүүлэхээр 100 хувийн саналаар дэмжсэн дүгнэлт гаргасан.

ТУЗ нь Компанийн дүрмийн дагуу 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ёстой ба ердийн 6 гишүүнээс одоо 5 гишүүн байгаа. Дутуу байгаа ердийн 1 гишүүнд компанийн хувьцаа эзэмшигч Анд Системс ХХК-аас тус компанийн Гүйцэтгэх захирал Цэвэгжав овогтой Одмааг ердийн гишүүнд нэр дэвшүүлэх санал ирүүлсэн. Уг асуудлыг ЗНДЦУ-ын хороогоор хэлэлцэн дүгнэлт гаргасан **/ЗНДЦУ-ын хорооны 2020.02.03-ны өдрийн хурлын дүгнэлтийг хавсаргав/**.

Иймд ТУЗ-ийн санал оруулж байгаа 9 гишүүнийг томилох санал хураалтад оролцож саналаа өгнө үү хэмээн хувьцаа эзэмшигч та бүхнээс хүсч байна.

Томилогдох 9 гишүүнийг хувьцаа дээмшигчдэд танилцуулав.

Хэлэлцрх асуудал 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах

Танилцуулсан нь: О.Болдбаатар

ТУЗ-ийн 2020 оны төсвийн санал 153 сая төгрөг. Үүнээс 143 сая төгрөгийг цалин урамшуулалд, 10 сая төгрөгийг хурал зохион байгуулахад зарцуулах саналыг оруулж байна. Компанийн төсвийг ТУЗ-өөс баталдаг, харин ТУЗ-ийн төсвийг ХЭЭХ-аас баталдаг учир ТУЗ-ийн санал болгосон төсвийг хэлэлцүүлэн батлуулахаар санал болгож байна. ЛэндМН-ийн дүрмийн дагуу ТУЗ 9 гишүүнтэй байх ба ТУЗ-ийн дэргэд 3 хороод ажиллана. Цалин урамшууллын хэмжээний хувьд Монголын хөрөнгийн бирж дээр байгаа хувьцаат компаниудын жишигтэй харьцуулж гаргасан. Энэ төсөл ХЭЭХ-аар батлагдвал 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөөд явах юм.

Та бүхнийг ТУЗ-ийн 2020 оны төсвийг батлах санал хураалтад саналаа өгөхийг хүсч байна.

Хэлэлцэх асуудал 5: Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн батлах эсэх асуудал

Танилцуулсан нь: О.Болдбаатар

ЛэндМН ББСБ ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлттэй холбоотой материалыг хурлын танилцах материалд дэлгэрэнгүй оруулсан. Та бүхэн материалтай бүхэн танилцсан байх.

ХЭЭХ-аар батлуулахаар оруулж буй дүрмийн өөрчлөлтүүдийн хувьд дүрмийг сайжруулах, давхардсан агуулгатай заалтуудыг хасах, зарим шинэ заалт нэмэхтэй холбоотой өөрчлөлтүүд байгаа. Компанийн дүрэм 5 бүлэг, 25 зүйл, 137 хэсэг заалттай. Дүрэмд өнгөрсөн онд нэг удаа өөрчлөлт оруулж байсан.

Нийт 9 заалтад өөрчлөлт оруулах санал орж байгаа. Үүнээс гадна компанийн 5 хувиас дээш хувьцаатай хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийнхээ хүрээнд Анд системс ХХК-аас Компанийн хуульд заасан хугацаанд ХЭЭХ-аар хэлэлцэх асуудалтай холбоотой дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг ирүүлсэн. ЛэндМН өнгөрсөн онд СЗХ-оос 2 тусгай зөвшөөрөл нэмж авсан. Эдгээр зөвшөөрөл нь компанийн дүрэмд зайлшгүй тусгагдсан байх шаардлагатай, дүрэмд уг заалтуудыг нэмэлтээр оруулах санал ирүүлсэн.

Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлттэй холбоотой заалтуудын дэлгэрэнгүй байдлаар дэлгэц дээр харуулж байгаа. Иймд хувьд эзэмшигчид Та бүхэн сайтар танилцан, дүрэмд оруулах өөрчлөлт тус бүрээр санал өгөхийг хүсч байна.

Хэлэлцэх асуудал 6: Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн батлах

Танилцуулсан нь: Б.Дэлгэржаргал

ЛэндМН-ий үйл ажиллагаа тогтмол өсөлттэй, ялангуяа өнгөрсөн жил 2.5 дахин өссөн. Энэ жилийн хувьд нийт активын хэмжээ 70 тэрбум гаруй байхаар төлөвлөгдөж байна. Бизнесийн үйл ажиллагаа өргөжихийн хирээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага гардаг. Үүнтэй холбоотой СЗХ-ны тодорхой зохицуулалтууд байдаг ба өөрийн хөрөнгө нь нийт активын 20 хувиас доошгүй байх ёстой гэсэн шаардлага тавигддаг. Компанийн хувьд 2019 оны эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 27 хувь байна. Хууль эрхзүйн хувьд, СЗХ-оос гаргасан журмын хүрээнд зөвхөн хувьцаа гаргах хэлбэрээр буюу хувь нийлүүлсэн хөрөнгөөс гадна хоёрдогч өглөг хэлбэрээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломж байдаг. Зохицуулалтын дагуу өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй буюу өнөөдрийн ЛэндМН-ий өөрийн хөрөнгөтэй харьцуулахад 7 тэрбум төгрөгийг хоёрдогч өглөгөөр татаж, нэмэгдүүлэх боломж байна гэсэн үг.

Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахад зайлшгүй ХЭЭХ-аар шийдвэрлүүлэх ёстой гэсэн шаардлага байдаг. Үүнтэй уялдуулан ТУЗ-өөс өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлсе, ингэхдээ 2020 онд 5 хүртэл тэрбум төгрөгийн зээлийн гэрээ байгуулах эрхийг ТУЗ-д олгоё гэдэг саналыг ХЭЭХ-д оруулж байна. “Хоёрдогч өглөг” гэдэг нь тодорхой хэмжээний урт хугацаатай зээл. Өөрөөр хэлбэл энэ нь хугацаа дууссаны эцэст Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, мөн санхүүгийн аливаа хүндрэлд орлоо гэхэд энэхүү хоёрдогч өглөгөөр авсан зээл нь бусад өр төлбөрүүдийг төлсөний дараа буюу хувь нийлүүлсэн хөрөнгө төлөгдөхөөс өмнө төлөгддөг буюу хоёрдогч дараалалтай зээл юм. ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур тооцож, хяналт тавих журамд хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн нөхцөлүүдийг заасан байдаг.

Иймд хувьцаа эзэмшигч Та бүхэн энэ саналыг хүлээн авч, батална гэдэгт найдаж байна.

АСУУЛТ/ ХАРИУЛТ: Асуултыг ЛэндМН ББСБ ХК-ийн Санхүү, үйл ажиллагаа хариуцсан газрын захирал, ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал асуув.

Гүйцэтгэх удирдлагын зүгээс хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултыг багцлан холбогдох хариултыг өгөв.

Асуулт 1: Компанийн хувьцаа яагаад унаад байна вэ? Цаашид унах магадлалтай байна. Үүнд тайлбар өгнө үү.

Өнгөрсөн 5 дахь өдрийн байдлаар ЛэндМН-ий хувьцааны ханш 31 төгрөг болсон. Компанийн үйл ажиллагаа хэвийн явж байна. Компани талаасаа харвал хувьцааны ханш унах ямар нэгэн нөхцөл байдал үүсээгүй. Дэлхий дахинаа короно вирусийн тархалттай холбоотойгоор олон улсын болон Монголын хөрөнгийн биржийн индексүүд уналттай буюу зарим хувьцаат компанийн хувьцааны индексүүд 30, 40, 50 хувь хүртэл унасан байгаа. Иймээс хувьцааны ханш унаж байгаад гадны хөрөнгийн зах зээлийн нөлөө байна уу гэж харж байна.

Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцаат компаниудын хувьцааны ханшийн үзүүлэлтүүдийг харвал ихэнх нь хувьцааны анхны ханшаасаа уналттай байгаа. ЛэндМН-ий хувьцаа 25 төгрөгөөр гараад 70 төгрөг хүртэл өсч байсан. Өнөөдрийн ханшийг харвал анх гарч байсан ханшаас даруй 25%-ийн өсөлттэй байна. Олон улсын ижил төрлийн финтек компаниудтай харьцуулахад ЛэндМН-ий хувьцаа харьцангуй хямд байгаа. Сүүлийн үед олон улсад хувьцааны ханш буурсантай холбоотойгоор ЛэндМН-ийн хувьцааг авъя гэсэн хөрөнгө оруулагчид нэлээд гарч ирж байна. Гэвч короно вирусийн тархалттай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулагчид маань захиалгаа өгч чадахгүй байна.

Монголд ЛэндМН-ий хувьцааг авахыг хүссэн хүмүүс байвал ажлын өдрүүдэд брокер, диллерийн компаниуд дээр очиж захиалгаа өгөөд авах боломжтой. Манай хувьцааны ханш цаашид өснө гэсэн хүлээлттэй байгаа.

Асуулт 2: Супер Ап компани танай компанитай ямар холбоотой вэ?

Шинээр Супер Ап аппликэйшн гарсан байгааг та бүхэн мэдэж байгаа байх. Энэ апп-д ЛэндМН-ий зарим үйлчилгээ ороод явж байгаа ба апп-ийн нээлтийг нэлээд томоор хийхээр төлөвлөж байсан боловч короно вирусээс шалтгаалан хийж чадаагүй. Супер Ап бол ЛэндМН өөрийн толгой компани Анд системс ХХК-тай хамтран гаргаж байгаа ЛэндМН-ий дараагийн дэвшилтэт хувилбар гэж ойлгож болно. Мөн Супер Ап апп-ийг гаргах болсон шалтгаан нь ЛэндМН компани нь ББСБ статустай, СЗХ-оос зөвшөөрлүүдээ аваад явдаг, зөвшөөрөлд дурдагдаагүй үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Монголбанкинд төлбөр тооцооны шинэ хууль батлагдсантай холбоотойгоор ЛэндМН цахим мөнгөтэй холбоотой нэмэлт зөвшөөрөл авах шаардлага үүссэн. Үүний тулд Супер Ап Хэтэвч ХХК охин компанийг байгуулаад, Монголбанкнаас нэмэлт тусгай зөвшөөрөл авахаар ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 2 өөр байгууллагын зохицуулалттай үйл ажиллагаа учир тусад нь салгаж явуулж байгаа. ЛэндМН борлуулалтынхаа хувьд 2 сувагтай болж байна гэж үзэж болно.

Асуулт 3: ЛэндМН зээлээ зогсоосон гэж ойлгож байгаа. Хэр удаан үргэлжлэх вэ?

Короно вирус гарсантай холбоотойгоор компанийн зүгээс сүүлийн 1 сарын хугацаанд нэлээд хэдэн шийдвэрүүдийг гаргасан. Фэйсбүүк хуудсаараа тухай бүрт харилцагчиддаа мэдээлээд явж байсан. ЛэндМН зээл олгохоо больсон гэсэн буруу ойлголт байх шиг байна. Үйл ажиллагаа хэвийн, зээлийг зогсоосон зүйл байхгүй. Харин шинэ хэрэглэгчдийг бүртгэх, шинээр зээл олгохыг түр хугацаанд зогсоосон. Хугацааны хувьд тухайн үеийн нөхцөл байдлаа харж байж шийдэх байх.

Монгол банкны ерөнхийлөгч болон Сангийн яамнаас хэрэглээний зээлүүдийн төлбөрийг хойшлуулахтай холбоотой мэдэгдэл гарсан. ЛэндМН-ий хэрэглэгчид 30 хоногт зээлээ буцаан төлөх ёстой байдаг. Дээрх мэдэгдэлтэй холбоотой 4 сарын 30-ны өдөр хүртэл ЛэндМН-ий хэрэглэгчид авсан зээлийнхээ өнгөрсөн хугацааны шимтгэлийг төлөөд хэдэн ч удаа сунгах боломжийг нийт харилцагчиддаа олгоод явж байна.

Мөн ЛэндМН-ий хэрэглэгчид зээл аваад хугацаандаа төлөх бүрт нэмэлт оноо ордог. Тэгвэл тухайн оноогоо ашиглаад шимтгэлээ буруулдаг болсон. Зээлийн нөхцөл өөрчлөх үед ямар нэгэн нэмэлт шимтгэл авахгүй байх талаар Засгийн газрын зөвлөмж гарсан. Манай харилцагчдын хувьд тухайн хүн зээлээ сунгалаа гэхэд шимтгэл авдаггүй.

ЛэндМН-ий зээл олголтын шийдвэрийг хиймэл оюун ухаан гаргадаг. Иймд ямар харилцагчид хэдэн төгрөгийн зээл өгөх, өгөхгүйг хиймэл оюун ухаан шийддэг. Тухайн харилцагч зээлээ удаа дараа хоцорч төлөөд байвал дахин зээл өгөхгүй байх шийдвэр системээс гардаг.

Асуулт 4: Ногдол ашигаа хэрхэн авах вэ? Хэзээ, яаж авах вэ?

ТУЗ-ийн баталснаар ногдол ашгийг 4 сарын 30-нд багтаан олгох ёстой. Энэ удаагийн хуралд танилцуулагдсанаар ногдол ашиг тараах үндэслэл бүрдэж байна. Хэдний өдрөөс олгож эхлэх талаар фэйсбүүк хуудсаараа дамжуулж хувьцаа эзэмшигчиддээ мэдээлнэ. 2020 оны 02 сарын 25-ны өдрөөр хувьцаа эзэмшиж байсан бүх хүн ногдол ашиг авах эрхтэй. Хувьцааны дансанд Та бүхний ногдол ашиг автоматаар орсон талаар та бүхэнд мэдээлсний дараа хувьцаа эзэмшигчид өөрийн харьцдаг брокер, диллерийн компаниудад хандан хувьцааны дансанд байгаа ногдол ашигаа хүссэн банкны дансандаа авах боломжтой.

Асуулт 5: Корона вирус танайд хэрхэн нөлөөлж байна вэ? Ямар арга хэмжээнүүд авч байна вэ?

Энэ нөхцөл байдлын үед харилцагчдаас гадна ажилтнууддаа маш сайн анхаарал хандуулах ёстой. Улс даяар 7 хоног бүтэн каринтилахад бүх ажилчидаа гэрээс нь ажиллуулсан. Технологи дээр суурилсан компани учир хамгийн эхэнд авч болох боломжит арга хэмжээ байсан.

Харилцагчтай холбоотой зээлийн хугацааг сунгах боломжийг олгож байна. Шимтгэл бууруулах ажлыг хийж байна. Хувьцаа эзэмшигчдийн хувьд санхүүд нөлөөлөх үү гэдэг талаас нь анхаарч асууж байгаа байх. Одоогоор чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх гэх мэт асуудал ажиглагдаагүй байна. Учир нь бидний зүгээс урьдчилсан арга хэмжээнүүдийг маш сайн авч ажиллаж байгаа.

Асуулт 6: Шинэ харилцагчидтай гэрээ байгуулахгүй гэж байсан. Энэ ямар учиртай вэ, хэзээ гэрээ байгуулж эхлэх вэ?

Улс орон өндөржүүлсэн бэлэн байдалтай ажиллаж байгаа үед хэрэглэгчдээ ирүүлэхгүйг хичээж байна. Учир нь ЛэндМН-ий хэрэглэгчийн хувьд зээл авахын тулд заавал нэг удаа ирж гэрээ зурах шаардлагатай байдаг. Нөхцөл байдлыг харж байгаа, өндөржүүлсэн бэлэн байдал дуусах үед хэлэлцэж шийдвэрлэнэ. Бидний хувьд энэ цаг үед шинэ харилцагч нэмэхээсээ илүү одоо байгаа хэрэглэгчиддээ үйлчилгээгээ сайн үзүүлээд явах, зээлээ цаг хугацаандаа төлөх боломж олгоход түлхүү анхаарч байна.

Асуулт 7: Зээл хэзээ хэвийн олгож эхлэх вэ?

Зээл хэвийн олгогдож байгаа.

Асуулт 8: Зээлийн хугацаа сунгалттай холбоотой асуултууд нэлээд ирсэн байна. Энэ талаар тайлбар өгвөл.

ЛэндМН-ий зээлтэй харилцагчид бол мэдэж байгаа байх. Авсан зээлээ зээлийн хугацааны төгсгөлд заавал төлөх ёстой байдаг. Мөн төлөх боломжгүй тохиолдолд зээлийн шимтгэлээ төлөөд 1 удаа сунгах боломжийг олгодог байсан. 2020 оны 3 сарын 27-ны өдрөөс эхлэн бүх харилцагчид маань авсан зээлээ эргэн төлөх хугацаа болох үед хугацааг нь сунгах боломжийг олгосон. Энэ арга хэмжээг 2020 оны 4 сарын 30-ны өдөр хүртэл үргэлжлүүлэх шийдвэр гарсан. Энэ хугацааг сунгах, сунгахгүй эсэхийг нөхцөл байдлаа харж байж тухайн үедээ шийдээд явна. ЛэндМН-ий харилцагчид маань короновирусээс шалтгаалан зээлийн эргэн төлөлтөд ямар нэгэн хүндрэл учирсан бол апп-руугаа ороод зээлээ хэдэн ч удаа сунгах боломжтой байгаа.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал хураалт эхлэв. Санал өгөх хугацаа 15 минут.

Тооллогын комиссын дарга Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлээкс ХХН-ийн партнер С.Батбуян тооллогын дүнг уншиж танилцуулав.

Саналын дүнг нэгтгэж дууслаа. Ирцийг дахин сануулж, тодруулах нь зүйтэй гэж үзэж байна. Компани нийт 800,000,000 ширхэг хувьцаатай. Үүнээс саналын эрхтэй 796,000,000 ширхэг хувьцаа байгаа. Халаасны 4,000,000 хувьцаатай. Саналын эрхтэй 4,259 хувьцаа эзэмшигч байгаа. Саналын эрхтэй хувьцаанаас өнөөдрийн хуралд 642,780,384 ширхэг хувьцаатай хувьцаа эзэмшигч оролцсон байгаа нь компанийн нийт саналын эрхтэй хувьцааны 80.75% буюу 80 хувьцаа эзэмшигч оролцож санал өгсөн байна.

Санал хураалтын дагуу үр дүнг нэг бүрчлэн танилцуулаад явъя.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮН:

- 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтын дүн:*

Зөвшөөрсөн: 642,758,550 (100%)

Татгалзсан: 23 (0%)

Түтгэлзсэн: 0 (0%)

- 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах тухай санал хураалтын дүн:*

Зөвшөөрсөн: 642,538,186 (99.97%)

Татгалзсан: 4,358 (0%)

Түтгэлзсэн: 216,029 (0.03%)

- 3. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн батлах тухай санал хураалтын дүн*

- 3.1. Компанийн дүрмийн 8.4.12 заалтыг хүчингүй болгох*

Зөвшөөрсөн: 642,371,004 (99.94%)

Татгалзсан: 183,284 (0.03%)

Түтгэлзсэн: 204,285 (0.03%)

- 3.2. Компанийн дүрмийн 8.5.7 заалтыг хүчингүй болгох*

Зөвшөөрсөн: 639,114,424 (99.43%)

Татгалзсан: 3,386,723 (0.53%)

Түтгэлзсэн: 257,426 (0.04%)

- 3.3. Компанийн дүрмийн 8.11 заалтыг өөрчлөх*

Зөвшөөрсөн: 642,151,845 (99.91%)

Татгалзсан: 606,728 (0.09%)

Түтгэлзсэн: 0 (0%)

- 3.4. Компанийн дүрмийн 9.6.11 заалтыг өөрчлөх*

Зөвшөөрсөн: 642,746,366 (100%)

Татгалзсан: 12,207 (0%)

Түтгэлзсэн: 0 (0%)

3.5. Компанийн дүрмийн 9.7 заалтыг өөрчлөх

Зөвшөөрсөн: 642,747,238 (100%)

Татгалзсан: 3,968 (0%)

Түтгэлзсэн: 7,367 (0%)

3.6. Компанийн дүрмийн 14.6.3 заалтыг өөрчлөх

Зөвшөөрсөн: 642,722,432 (100%)

Татгалзсан: 6,930 (0%)

Түтгэлзсэн: 29,211 (0%)

3.7. Компанийн дүрмийн 19.2 заалтыг өөрчлөх

Зөвшөөрсөн: 642,720,907 (99.99%)

Татгалзсан: 37,666 (0.01%)

Түтгэлзсэн: 0 (0%)

3.8. Компанийн дүрмийн 20.6 заалтыг өөрчлөх

Зөвшөөрсөн: 642,751,364 (100%)

Татгалзсан: 150 (0%)

Түтгэлзсэн: 0 (0%)

3.9. Компанийн дүрмийн 22.2 заалтыг өөрчлөх

Зөвшөөрсөн: 642,741,994 (100%)

Татгалзсан: 4,095 (0%)

Түтгэлзсэн: 5,425 (0%)

3.10. Компанийн дүрмийн 22.3 заалтыг хүчингүй болгох

Зөвшөөрсөн: 642,596,582 (99.98%)

Татгалзсан: 154,932 (0.02%)

Түтгэлзсэн: 0 (0%)

3.11. Компанийн дүрмийн 4.2.8 заалтыг нэмэх

Зөвшөөрсөн: 642,666,424 (100%)

Татгалзсан: 0 (0%)

Түтгэлзсэн: 23 (0%)

3.12. Компанийн дүрмийн 4.2.9 заалтыг нэмэх

Зөвшөөрсөн: 642,666,274 (100%)

Татгалзсан: 150 (0%)

Түтгэлзсэн: 23 (0%)

4. Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх тухай санал хураалтын дүн:

4.1 Өөрийн хөрөнгийг 5,0 тэрбум хүртэл төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн батлах тухай санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 642,040,228 (99.90%)

Татгалзсан: 597,831 (0.10%)

Түтгэлзсэн: 28,388 (0.00%)

4.2. Хоёрдогч өглөгийн нөхцөлийн холбогдох хууль тогтоомжийн дагуу батлах болон гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх эрхийг компанийн ТУЗ-д олгох санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 642,653,688 (100%)

Татгалзсан: 150 (0%)

Түтгэлзсэн: 12,609 (0%)

5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох санал хураалтын дүн:

5.1. ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч О.Болдбаатар

Зөвшөөрсөн: 647,351,716 (16.81%)

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Дэлгэржаргал

Зөвшөөрсөн: 639,301,321 (16.60%)

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч В.Баярсайхан

Зөвшөөрсөн: 630,948,265 (16.39%)

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Н.Цэвэгмид

Зөвшөөрсөн: 693,238,986 (18.01%)

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч С.Энх-Амгалан

Зөвшөөрсөн: 613,519,673 (15.94%)

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Ц.Одмаа

Зөвшөөрсөн: 625,738,993 (16.25%)

5.2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Ч.Номин

Зөвшөөрсөн: 644,020, 673 (33.45%)

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч С.Боргил

Зөвшөөрсөн: 641,921, 274 (33.35%)

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Ж.Жаргалсүрэн

Зөвшөөрсөн: 639,087, 469 (33.20%)

Хэлэлцэх асуудалтай холбоотой хүчингүй болсон саналын хуудас байхгүй.

О.Болдбаатар: Тооллогын дүнд үндэслэн ХЭЭХ-аас гарах шийдвэрүүдийг танилцуулахын өмнө асуулт, хариултын цаг дууссанаас хойш нэлээд олон асуултууд нэмж ирлээ. Эдгээрээс 2 асуултад онцгойлон тайлбар тавих нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Асуулт 9: Компани өнгөрсөн оны ХЭЭХ-аар тодорхой хэмжээний хувьцаа халааслана гэж яригдаж байсан. Тухайн хувьцааг халаасалсан уу?

Өнгөрсөн оны ХЭЭХ-аар шийдвэрлэсний дагуу 4 сая ширхэг хувьцааг ЛэндМН өөрөө халаасалсан. Энэ хувьцаа санал хураалтад ороогүй, санал өгөхөд тоологдохгүй байгаа. Халаасалсан хувьцааг хүний нөөцийн дунд хугацааны бодлогын дагуу ирэх ондоо ажилтнууддаа хуваарилах асуудал ТУЗ-өөр хэлэлцэгдэн, шийдвэрлэгдээд ажилчиддаа олгоод явна.

Асуулт 10: Кодоо авч чадаагүй байсан хувь нийлүүлэгч саналаа өгөх боломжгүй юу?

Компанийн тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчид заавал өөрийн биеэр ирж өөрийгөө таниулж, кодоо авах ёстой байгаа. Хурал зарласан өдрөөс эхлэн энэ тухай хувьцаа эзэмшигчиддээ зарлаж байсан.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцуулав /ХЭЭХ-аас гарсан шийдвэрийг хавсаргав/.

